

МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН ЗАХ ЗЭЭЛД ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ “ЭНАП” ЭМИЙН МАРКЕТИНГИЙН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Ө.Үүрийнтуяа¹, Т.Ахтолхын¹, А.Баянмөнх²
¹ЭЗШУИС, ²Эм судлалын хүрээлэн
e-mail: uzem_uuree@yahoo.com

SOME RESULTS OF THE MARKETING RESEARCH FOR “ENAP” MEDICINE THAT'S USED COMMON IN PHARMACEUTICAL MARKETS, MONGOLIA

Uuriintuya.U¹, Akhtolkhyn.T¹, Bayanmunkh.A²
¹Mongolian University of Pharmaceutical sciences, ²Drug research Institute
e-mail: uzem_uuree@yahoo.com

Background: Today over 1 million people have hypertension in the world. 1.5 billion people have symptoms of the diseases living difficulty. The hyperpiesis is 64% brain hemorrhage causes, and 49% of heart attack diseases. Blood pressure or hyperpiesis is the leading cause of adult diseases in Mongolia. With hypertension diagnoses, 19811 people hospitalized in patient treatment and 46022 people have received outpatient care through Mongolia. The most present of Mongolians regularly use medicines for reducing arterial pressure. In this research, we chosen the Enap medicine that is used common; 5 mg, 10 mg and 20 mg Enap are used at imported and domestic industry in the pharmaceutical market, Mongolia.

Aim: To research some indicators of Enap pharmaceutical market which is used common in the treatment by Mongolians.

Method: Based on the statistics from Mongolian Customs, when we research about the Enap market, we used the drug economic analysis methods including comparative research methods and content analysis research methods, respectively.

Results: Our result shows that the 66.7% of all Enap in Mongolian pharmaceutical market is imported, and other 33.3% medicine is produced in domestic manufacturers, Mongolia. In Mongolia, 8 companies imports the Enap medicines from the biggest farms like KRKA, Denk Pharma, Berlin Chemie and Akrihin-akri. In the comparison research for Enap sales, there are 8 importer companies, the X1 company sells the most, and it's 22.4 times much than the lowest sales. In the research for Enap /10mg/ average prices, the imported products cost 324 MNT but the domestic products cost 1525 MNT.

Судалгааны ажлын үндэслэл

Өнөөдөр дэлхий дээр артерийн даралт ихсэх өвчнөөр 1 тэрбум хүн өвдөж, 1,5 тэрбум хүн артерийн даралт ихсэх өвчний зовиуртай амьдарч байна. Цусны даралт ихсэх өвчин нь тархинд цус харвах шалтгааны 64%, зүрхний шигдээсөвчний 49%-ийг эзэлдэг. Цусны даралт ихсэлт нь Монгол Улсад насанд хүрэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байна. Монгол Улсын хэмжээнд артерийн даралт ихсэх өвчний оноштойгоор 19811 хүн хэвтэн эмчлүүлж, 46022 хүн амбулаторийн тусламж үйлчилгээ авсан байна¹. Монгол Улсын хүн амын дийлэнх хувь нь артерийн даралт бууруулах эм байнга хэрэглэдэг болохыг

бусад судлаачид судалсан байна.

Иймээс бид энэхүү судалгаандаа Энап эмийг сонгон авсан бөгөөд одоогоор Монгол Улсын эмийн зах зээл дээр импортын болон дотоодын үйлдвэрийн 5мг, 10мг, 20мг-ийн Энап эмийг хэрэглэж байна.

Судалгааны ажлын зорилго

Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэгдэж буй Энап эмийн зах зээлийн зарим үзүүлэлтийг судлах.

Судалгааны ажлын зорилт

Монгол Улсын эмийн зах зээлд хэрэглэгдэж буй Энап эмийг үйлдвэрлэгчээр нь ангилан, эрэмблэх

Монгол Улсад импортоор орж ирж буй Энап эмийн татан авалтыг судлах


Энап эмийн борлуулалтын дундаж үнийг харьцуулан судлах

Судалгааны ажлын материал, арга зүй

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэл дээр үндэслэн Энап эмийн зах зээлийг судлахдаа эмийн эдийн засгийн шинжилгээний аргууд болох харьцуулан судлах, контент судалгааны аргыг тус тус ашигласан болно.

Судалгааны ажлын үр дүн


Бид 1-р зорилтын хүрээнд Монгол Улсын эмийн зах зээл дээр хэрэглэгдэж буй Энап эмийг үйлдвэрлэгчээр нь ангилан, эрэмблэж судалгааны дүнг дараах зургаар харууллаа.



Зураг 1. Энап эмийг үйлдвэрлэгчээр нь ангилсан байдал

Дээрх зургаас харахад Монгол Улсын эмийн зах зээлд хэрэглэгдэж буй нийт Энап эмийн 66.7% нь импортын, 33.3% нь дотоодын үйлдвэрийнх байна. Судалгаанаас үзэхэд импортоор орж ирж буй нийт Энап эмийн 30.8% нь KRKA, 15.4% нь Denk Pharma, 10.3% нь Berlin Chemie, 10.3% нь Акрихин-Акри пүүсийнх байна.


Монгол Улсын хэмжээнд нийт 8 компани Энап эмийг KRKA, Denk Pharma, Berlin Chemie, Акрихин-Акри зэрэг пүүсүүдээс 5мг, 10мг, 20мг-ын тун хэмжээтэйгээр импортлож байна. Дээрх пүүсүүдээс импортоор орж ирж буй Энап эмийн татан авалтыг дараах зурагт харууллаа. /Ам.доллар/



Зураг 2. Энап эмийн татан авалтын байдал /2015 он/

Судалгааны дүнгээс харахад X1 компаний татан авалтын дүнг X2 компанийхтай харьцуулахад 1.88 дахин их, X8 компани буюу хамгийн багатай нь харьцуулахад 22.4 дахин их байлаа.

Монгол Улсын эмийн зах зээл дээр борлуулагдаж буй Энап 10мг эмийн дундаж үнийг харьцуулан судалсан дүнг дараах зургаар илэрхийлэв. /Төгрөг/



Зураг 3. Энап 10мг эмийн дундаж үнэ

Зураг 3-аас харахад Монгол Улсын эмийн зах зээл дээр хэрэглэгдэж буй Энап 10мг №20 эмийн дундаж үнийг харьцуулан судлахад импортоор орж буй KRKA пүүсийнх 4290 төгрөг буюу хамгийн өндөр, Акрихин-Акри пүүсийнх хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр тус тус борлогдож байна. Харин дотоодын үйлдвэрлэгчдээс Монос фарм ХХК-ийнх 1600 төгрөг, Нахиа эмийн үйлдвэрийнх 1450 төгрөг тус тус байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсын эмийн зах зээлд хэрэглэгдэж буй Энап эмийн 66.7% импортынх, 33.3% нь дотоодын үйлдвэрийнх байна. Энап эмийн татан авалтыг судлахад нийт 8 импортлогч компаниас Х1 компани хамгийн их татан авалттай ба хамгийн багатай нь харьцуулахад 22.4 дахин их байна. Энап 10 мг №20 эмийн борлуулалтын дундаж үнийг судлан

үзэхэд импортынх 3247 төгрөг, дотоодын үйлдвэрийнх 1525 төгрөгийн дундаж өртөгтэй байгаа нь бидний судалгаагаар нотлогдлоо.

Ном зүй

1. Нарантуяа М. Артерийн даралт ихсэх өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх судалгаа. 2015
2. Монос-Фарм ХХК Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл -0002 – 2012